



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/885

Ховд

Орон тооны бус зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 4 дүгээр сарын 28-ны 43 дугаар тушаалын 2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний болон орон нутгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, удирдлагаар хангах, хяналт тавих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтэц хариуцсан орлогч
- Зөвлөлийн гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
  - Аймгийн Иргэдийн хурлын Олон нийт, иргэдтэй харилцах хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
  - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

- Аймгийн Стандарчлал хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Аймгийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн
- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
- Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга
- Аймгийн Эрчим хүчний Зохицуулах зөвлөлийн зохицуулагч
- Аймгийн Баялаг бүтээгчдийн холбооны тэргүүн
- “Баруун бүсийн Хүний эрх, иргэний оролцоо хөгжил” төрийн бус байгууллагын зохицуулагч
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хэмжих “Дэвшил” холбооны гүйцэтгэх захирал

Зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга:

- Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч

2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралдаанаараа хэлэлцэн баталж, ажлын тайланг тухай бүр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Аймгийн Засаг даргад тайлангаж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/801 дүгээр захирамжийг хүчингүйд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ